

---

БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН ДУГААР 9191-MON(EF)

БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН ГЭРЭЭ

(Гадаад эх үүсвэрээс санхүүжсэн)

(Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Оролцоог Хангах, Үйлчилгээ Үзүүлэх Төсөл)

МОНГОЛ УЛС

болон

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ

хооронд

ҮЗЭГЛЭСЭН ОГНОО \_\_\_\_\_

---

MON 48076

**БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН ГЭРЭЭ**  
**(Гадаад эх үүсвэрээс санхүүжсэн)**

БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙН ГЭРЭЭГ МОНГОЛ УЛС (“Хүлээн авагч”) болон  
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (“АХБ”)-ны хооронд \_\_\_\_\_ өдөр үзэглэв.

**ДАРААХЫГ ХАРГАЛЗАН**

(А) Хүлээн авагч болон АХБ-ны (“Зээлийн Гэрээ”) хооронд байгуулсан зээлийн гэрээний дагуу, АХБ нь АХБ-ны ердийн санхүүгийн эх үүсвэрээс хорин таван сая долларыг (\$25,000,000) АХБ-ны Зээлийн Гэрээний Хавсралт 1-д заасан төслийг санхүүжүүлэх зорилгоор Хүлээн авагчид зээлдүүлэхийг зөвшөөрч;

(В) Япон улсын Засгийн Газар нь Японы Ядуурлыг Бууруулах Сангаар (ЯЯБС) дамжуулан 2009 оны 10 сарын 07-ны өдөр АХБ болон Японы Засгийн Газрын хооронд байгуулсан Зохицуулалтын Захидалд (“Зохицуулалтын Захидал”) тусгагдсан нөхцлүүдийн дагуу буцалтгүй тусламжийг олгож, АХБ-аар уг тусламжийг удирдан зарцуулахаар тохирч;

(С) АХБ нь энд заасан нөхцлүүдийн дагуу ЯЯБС-ийн буцалтгүй тусламжийн хөрөнгийг Хүлээн авагчид олгохыг зөвшөөрч байна;

ИЙМД талууд дараах заалтуудыг хүлээн зөвшөөрч байна:

**ЗААЛТ I**

**Буцалтгүй тусламжийн журам; Тодорхойлолт**

Хэсэг 1.01. 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр батлагдсан АХБ-ны Гадаад эх үүсвэрээс санхүүжсэн Буцалтгүй Тусламжийн Журмын (“Тусламжийн Журам”) бүх заалтууд нь энэхүү Тусламжийн Гэрээнд ч мөн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Хэсэг 1.02. Энэхүү Тусламжийн Гэрээнд тусгагдсан ойлголтууд нь энд өөрөөр заагаагүй бол Тусламжийн Журам болон Зээлийн Гэрээнд тодорхойлсон агуулгаар ашиглагдана.

**ЗААЛТ II**

**Тусламж**

Хэсэг 2.01. АХБ нь ЯЯБС-ын хоёр сая долларын буцалтгүй тусламжийн хөрөнгийг (\$2,000,000) (“Тусламж”) авч Хүлээн авагчид олгохоор зөвшөөрч байна.

**ЗААЛТ III**

### Буцалтгүй тусламжийн хөрөнгийн ашиглалт

Хэсэг 3.01. Хүлээн авагч нь Тусламжийн хөрөнгийг энэхүү Тусламжийн Гэрээний нөхцлийн дагуу Төслийн зардлуудыг санхүүжүүлэхэд ашиглана.

Хэсэг 3.02. Тусламжийн хөрөнгийг энэхүү Тусламжийн Гэрээний Хавсралтад заасны дагуу гаргаж зарцуулах ба уг Хавсралт нь Хүлээн авагч болон АХБ-ны тохиролцсоны дагуу үе үе шинэчлэгдэж болно.

Хэсэг 3.03. АХБ өөрөөр тохироогүй бол Хүлээн авагч нь Зээлийн Гэрээний Хавсралт 4-т заасан Тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлын зүйлүүдийг худалдан авах ажиллагааг зохион байгуулна, эсвэл худалдан авахад хүргэнэ.

Хэсэг 3.04. Тусламжийн Данснаас Бараа, Ажил болон Зөвлөхийн Үйлчилгээтэй холбоотой хөрөнгийг татан авахдаа зөвхөн зардлын данснаас гаргах бөгөөд дараах шалгуурыг хангах ёстой:

- (a) Барааг үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн, Ажил болон Зөвлөх үйлчилгээг нийлүүлэх улсууд нь АХБ-ны худалдан авах ажиллагааны журамд (үе үе шинэчлэгддэг) оролцох эрхтэй хэмээн тодорхойлсон АХБ-ны гишүүн улсууд байх ёстой; бөгөөд
- (b) Бараа, Ажил, Зөвлөх үйлчилгээ нь АХБ-ны худалдан авах ажиллагааны журамд (үе үе шинэчлэгддэг) заасан оролцох эрхийн бусад шаардлагуудыг хангасан байх ёстой.

Хэсэг 3.05. Тусламжийн Журмын Хэсэг 8.02-т заасан Буцалтгүй Тусламж Хаагдах Хугацаа нь 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр эсвэл Хүлээн авагч болон АХБ-ны тохиролцсон өөр хугацаа байх болно.

## ЗААЛТ IV

### Тусгай гэрээ

Хэсэг 4.01. Төслийг хэрэгжүүлэх болон Төслийн байгууламжуудыг ажиллуулахдаа Хүлээн авагч нь Зээлийн Гэрээний Хавсралт 5-д заасан бүх үүрэг хариуцлагыг гүйцэтгэнэ, эсвэл гүйцэтгүүлнэ.

Хэсэг 4.02. (a) Хүлээн авагч нь (i) Төслийн хувьд тусдаа данстай байж, холбогдох бүртгэлийг хөтөлнө; (ii) Төслийн жилийн санхүүгийн тайлангуудыг АХБ-ны хүлээн зөвшөөрсөн санхүүгийн тайлангийн стандартын дагуу бэлтгэнэ; (iii) тэдгээр санхүүгийн тайлангуудыг жил бүр АХБ-ны хүлээн зөвшөөрсөн мэргэшил, туршлага, ажлын даалгавар бүхий хөндлөнгийн аудиторроор АХБ-ны хүлээн зөвшөөрсөн аудитын стандартын дагуу хянуулж, аудитын дүгнэлт гаргуулна; (iv) тэдгээр аудитын тайлан бүрдэл хэсэг болгож аудиторрууд нь тайлан бэлдэх ба уг тайланд санхүүгийн тайлангууд болон Буцалтгүй тусламжийн хөрөнгийн ашиглалтын талаарх аудиторын дүгнэлт, менежментийн захидал (хэрэв байгаа бол аудит хийх явцад илэрсэн Төслийн дотоод хяналтын алдаа дутагдлыг дурьдана) багтана; болон (v) холбогдох төсвийн жил дууссаны дараа 6 сараас хэтрүүлэхгүйгээр Англи хэл дээр орчуулагдсан

аудитлагдсан санхүүгийн тайлангууд, аудитын тайлан болон менежментийн захидлын хуулбаруудыг АХБ-нд хүргүүлнэ. Эдгээр бичиг баримт болон аудиттай холбоотой бусад мэдээллийг АХБ-аас үе үе тодорхой үндэслэлээр хүссэн тохиолдолд мөн хүргүүлнэ.

(b) АХБ нь Төслийн аудитлагдсан жилийн санхүүгийн тайлангууд болон санхүүгийн тайланд өгсөн аудитуудын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталгаажуулснаасаа хойш 14 өдрийн дотор АХБ-ны вэбсайтад байршуулна.

(c) Хүлээн авагч нь АХБ-ны хүсэлтээр АХБ-ийг төслийн санхүүгийн тайлангууд болон дээрх дэд хэсэг (a) (iii)-д заасан Төсөлд аудиторуудыг томилохтой холбоотой Хүлээн авагчийн санхүүгийн асуудлуудын талаар хэлэлцэх боломжоор хангаж, зөвшөөрөл олгох ба АХБ-аас хүссэний дагуу ийм хэлэлцүүлэгт аудиторуудын төлөөлөгчийг оролцуулахыг шаардана. Хүлээн авагч өөрөөр тохироогүй бол зөвхөн Хүлээн авагчийн эрх бүхий албан тушаалтан оролцсон нөхцөлд л ийм төрлийн хэлэлцүүлгүүдийг зохион явуулна.

**Хэсэг 4.03.** Хүлээн авагч нь АХБ-ны төлөөлөгчдийг Төсөл, Бараа, Ажил болон холбогдох бусад бүртгэл, баримт бичгийг шалгах нөхцлөөр хангана.

**Хэсэг 4.04.** Хүлээн авагч нь АХБ-ыг ЯЯБС-аас олгох буцалтгүй тусламжийг удирдан зарцуулагчийн үүргээр оролцохыг хүлээн зөвшөөрч, энэхүү Тусламжийн Гэрээг АХБ-тай байгуулж байна. Иймд, Хүлээн авагч нь (a) Буцалтгүй тусламжийн хөрөнгийг ЯЯБС-аас АХБ-ны авсан хэмжээгээр, мөн уг хөрөнгө нь Хамтын Санхүүжилтийн Гэрээнд заасны дагуу ЯЯБС-аас бүхэлд нь болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоосон эсвэл хүчингүй болгоогүй тохиолдолд л татан авч болох, бөгөөд (b) АХБ нь Төсөл эсвэл Буцалтгүй тусламжийн (Тусламжийн гэрээнд зааснаас бусад үүргүүд) хувьд ЯЯБС-ийн аливаа үүрэг, хариуцлагыг хүлээхгүй.

**Хэсэг 4.05.** Хүлээн авагч нь өөрөө болон Төслийг Хэрэгжүүлэгч Байгууллагыг ЯЯБС-ийн Танилцуулга болон Зохицуулалт Хийх Удирдамжийг мөрдөж ажиллуулна. Ялангуяа, Хүлээн авагч нь Төслийг Хэрэгжүүлэгч Байгууллагыг ЯЯБС-аас санхүүжсэн Төсөлтэй холбоотой олон нийтийн бүх мэдээлэл, хэвлэгдсэн тайлан, тоног хэрэгсэл болон байгууламжид ЯЯБС болон Японы Хөгжлийн Албан Ёсны Тусламжийн логонуудыг оруулахыг анхаарч ажиллана. Энэхүү заалтын дагуу ЯЯБС-ийн Танилцуулга болон Зохицуулалт Хийх Удирдамж гэдэгт АХБ болон Японы Засгийн газрын хооронд 2015 оны 04 сарын 10-ны өдөр байгуулсан (үе үе шинэчлэгддэг) "Японы харагдахуйц байдал болон Японы ЭСЯ, ЖАЙКА-тай уялдуулан зохицуулах удирдамжийн тэмдэглэл"-ийг ойлгоно.

## **ЗААЛТ V**

### **Хүчин төгөлдөр болох**

**Хэсэг 5.01.** Тусламжийн журмын Хэсэг 9.01(e)-д заасны дагуу энэхүү Тусламжийн Гэрээг зохих ёсоор хүчин төгөлдөр болохын тулд дараах нэмэлт нөхцөл үйлчилнэ: Зээлийн гэрээг зохих ёсоор гүйцэтгэж хүргүүлэх бөгөөд уг гэрээ хүчин төгөлдөр болох бүх урьдач нөхцлүүд (энэхүү Тусламжийн гэрээг хүчин төгөлдөр болгохыг шаардсан нөхцлөөс бусад) бүрэн биелсэн байна.

Хэсэг 5.02. Тусламжийн журмын Хэсэг 9.02(с)-д заасны дагуу дараах нэмэлт асуудлыг санал эсвэл саналуудад оруулан АХБ-д хүргүүлнэ: Зээлийн Гэрээг зохих ёсоор зөвшөөрч эсвэл соёрхон батлах, бөгөөд Хүлээн авагчийн нэрийн өмнөөс гүйцэтгэж хүргүүлэх, түүнд заасан нөхцлийн дагуу Хүлээн авагч нь хууль ёсоор дагаж мөрдөх зэрэг болно.

Хэсэг 5.03. Тусламжийн журмын Хэсэг 9.04-т заасны дагуу энэхүү Тусламжийн Гэрээг байгуулснаас хойших 90 өдөр нь уг Тусламжийн Гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа юм.

## ЗААЛТ VI

### Бусад

Хэсэг 6.01. Хүлээн авагчийн Сангийн Яам нь Тусламжийн журмын Хэсэг 11.02-т заасны дагуу Хүлээн авагчийг төлөөлөх болно.

Хэсэг 6.02. Тусламжийн журмын Хэсэг 11.01-т заасны дагуу дараах хаягийг ашиглана:

#### Хүлээн авагчийн хаяг

Сангийн Яам  
Засгийн газрын II байр  
С.Данзангийн Гудамж 5/1  
Улаанбаатар 15160  
Монгол Улс

Факсын дугаар:

(976) 11-320247

#### АХБ-ны хаяг

Азийн Хөгжлийн Банк  
АХБ-ны Өргөн чөлөө 6  
Мандалуён Хот  
Метро Манилла 1550  
Филиппин Улс

Факсын дугаар:

(632) 636-2444  
(632) 636-2407.

Талуудын зохих ёсоор итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг ГЭРЧЭЭР БАЙЛЦУУЛАН дээр үзэглэсэн жил болон өдөр энэхүү Тусламжийн Гэрээг байгуулж, АХБ-ны төв оффист хүргүүлэхээр тохиров.

МОНГОЛ УЛС

---

ЧИМИДИЙН ХҮРЭЛБААТАР

Сангийн Сайд

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

---

ЁЛАНДА ФЕРНАНДЕЗ ЛОММЕН

Монгол дахь Суурин төлөөлөгч

## ХАВСРАЛТ

### Буцалтгүй тусламжийн хөрөнгийг татан авах болон зарцуулах

#### Ерөнхий

1. Энэхүү Хавсралтанд буй хүснэгтэд Тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардлын зүйлүүдийн Ангилал болон Ангилал тус бүрт ("Хүснэгт") зарцуулах дүнг тусгасан. (Энэхүү Хавсралтад заасан "Ангилал" гэдэгт Хүснэгтэд тусгасан Ангилалыг ойлгоно.)

#### Буцалтгүй тусламжийн данснаас мөнгө гаргах үндэслэл

2. АХБ-аас өөрөөр заагаагүй бол Буцалтгүй тусламжийн хөрөнгө нь зардлын зүйлсээр хуваарилагдах бөгөөд Хүснэгтэд заасан зардлын зүйл тус бүрээр татан авах мөнгөний хувь хэмжээнд үндэслэн зарцуулагдана.

#### Дахин хуваарилалт

3. Буцалтгүй тусламжийн хөрөнгийг хуваарилах болон Хүснэгтэд заасан мөнгө гаргах хувь хэмжээнээс үл хамааран,

- (a) хэрэв аль нэг Ангилалд хуваарилах Тусламжийн хөрөнгийн дүн нь уг Ангилалын зөвшөөрөгдсөн бүх зардлыг санхүүжүүлэхэд хангалтгүй байвал Хүлээн авагчтай зөвлөлдсөний үндсэн дээр АХБ нь (i) бусад зардлыг санхүүжүүлэхэд шаардлагагүй хэмээн АХБ-аас үзсэн Тусламжийн хөрөнгийн дүнг өөр Ангилалаас авч дутагдсан дүнгийн хэмжээгээр уг Ангилалд дахин хуваарилна (ii) хэрэв уг дахин хуваарилалт нь дутагдсан дүнг нөхөхөд бүрэн хүрэлцэхгүй бол тухайн Ангилалаар цаашид гаргах бүх зардлууд төлөгдөхүйц байхаар уг зардлуудад ноогдох мөнгө татах хувь хэмжээг бууруулна; болон
- (b) хэрэв аль нэг Ангилалд хуваарилах Тусламжийн хөрөнгийн дүн нь уг Ангилалын зөвшөөрөгдсөн бүх зардлаас илүү байвал Хүлээн авагчтай зөвлөлдсөний үндсэн дээр АХБ нь илүү гарах мөнгөн дүнг өөр Ангилал руу дахин хуваарилж болно.

#### Зарцуулах журам

4. АХБ-аас өөрөөр тохироогүй бол Тусламжийг хөрөнгө нь Зээлийн Зарцуулалтын Журмын дагуу зарцуулагдана.

